



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 31 өдөр

Дугаар 84

Хэрлэн сум

**Шалгалтын комисс байгуулах тухай**

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэг, 33.2, 33.2.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 1.6 дахь хэсэг 3.5, 3.5.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 6.2, 6.3, 6.5, 6.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулах шалгалтын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Шалгалтын комиссын

дарга:	Б.Дарханбаатар	Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ш.Эрдэнэжаргал	Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүн:	Б.Сүнгээ	Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Г.Сэдэмаа	Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн статистикийн хэлтсийн дарга
	С.Бат-Эрдэнэ	Салбар зөвлөлийн гишүүн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга

2. Төрийн албаны тусгай шалгалтыг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулахыг шалгалтын комисс /Б.Дарханбаатар/-д даалгасугай.

3. Төрийн албаны тусгай шалгалтын тайлан, судалгааг хугацаанд нь Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ТАНБААТАР

